



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 0165

Хэрлэн сум

"Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг дахиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол улсын Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчнийг орон нутаг, ард иргэдэд сурталчлах, цэрэг иргэний холбоог бэхжүүлэх зорилгоор "Монгол цэргийн өдөр"-ийг 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

Хоёр. "Монгол цэргийн өдөр"-ийн баярын арга хэмжээг зохион байгуулах комиссыг 1 дүгээр, хөтөлбөрийг 2 дугаар, зарцуулах төсвийг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Гурав. "Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тусгай төлөвлөгөө гаргаж хөтөлбөрт заагдсан арга хэмжээнүүдийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг зохион байгуулах комисст, тэмцээн уралдаан, ёслолын арга хэмжээнд зохион байгуулалттай оролцохыг цэргийн болон цэрэгжсэн байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

Дөрөв. "Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах 1911100 /нэг сая есөн зуун арван нэгэн мянга нэг зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн цэргийн дүйцүүлэх албаны зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс/С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 381

ЗЭВСЭГТ ХҮЧНИИ 96 ЖИЛИЙН ОЙ,  
"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙН БАЯРЫН  
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Комиссын дарга:	Ж.Ганбаатар	-АЗДТГ-ын дарга
Орлогч дарга:	Н.Хүрэлээ	-Цэргийн штабын дарга, дэд хурандаа
Гишүүд:	Н.Мягмарцоож	-Зэвсэгт хүчний 232-р ангийн захирагч, хурандаа
	Ж.Жамсрандорж	-Хилийн 0287-р ангийн захирагч, хурандаа
	Д.Батжаргал	-Онцгой байдлын газрын дарга, хурандаа
	О.Ганбат	-Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа
	Б.Нандинболор	-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, дэд хурандаа
	Ц.Идэрбат	-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
Нарийн бичгийн дарга:	Т.Баяраа	-Цэргийн штабын ОНХС-ын офицер

**ЗЭВСЭГТХҮЧНИЙ 96 ЖИЛИЙН ОЙ,  
"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙН  
БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

**3 дугаар сарын 11-нд Бямба гариг**

11.00 - Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Sniper" буудлагын тэмцээн  
/Батлан хамгаалахад туслах нийгэмлэг, Хэрлэн сумын ЗДТГ/


**3 дугаар сарын 16-нд Пүрэв гариг**

10.00 - Буудлагын тэмцээн /Хилийн 0287-р анги/  
12.00 - Гар бөмбөгийн тэмцээн /Цагдаагийн газар/  
16.00 - Үндэсний бөхийн барилдаан /нийтийн/ /Онцгой байдлын газар/  
18.00 - Шатрын багийн тэмцээн /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба/

**3 дугаар сарын 17-нд Баасан гариг**

10.00 - Жанжин Б.Пунцагийн хөшөөнд цэцэг өргөнө. /Цэргийн штаб/  
11.00 - Д.Сүхбаатарын одонт, хурандаа Ш.Дорж агсаны нэрэмжит "ЦЭРЭГ ЭРС -2017"  
марш тактикийн тэмцээн /Зэвсэгт хүчний 232-р анги/  
17.00 - "Хайрлан дуулах эх орон" цэрэг эх орны сэдэвт дууны тэмцээн  
/Хан хэнтий чуулга,  
Хэрлэн сумын ЗДТГ/  
18.00 - Дүн гаргаж, шагнал гардуулах ажиллагаа /Цэргийн штаб/

Аймгийн Засаг даргын 2017 оны .....  
 дугаар сарын ..... өдрийн ..... дугаар  
 захирамжийн гуравдугаар хавсралт



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 96 ЖИЛИЙН ОЙ,  
 "МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙН  
 БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Зардал	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1	"SNIPER" буудлагын тэмцээн	Медаль	9	2500	22500	
		Диплом	3	7500	22500	
		1-р байр	1	30000	30000	
		2-р байр	1	20000	20000	
		3-р байр	1	10000	10000	
		Шүүгч	5	5000	25000	
		<b>Бүгд</b>				<b>137500</b>
2	"ЦЭРЭГ ЭРС- 2016" Марш тактикийн аварга салаа шалгаруулах тэмцээн	Цом	1	30000	30000	
		Өргөмжлөл	3	10000	30000	
		1-р байр	1	500000	500000	
		2-р байр	1	300000	300000	
		3-р байр	1	200000	200000	
		Шүүгч	10	5000	50000	
		9 мм-ийн сум	96	1000	96000	
		7.62 мм-ийн сум	140	1500	210000	
<b>Бүгд</b>				<b>1416000</b>		
3	Бусад зардал	Спорт залны төлбөр	1	150000	150000	
		Анонс	16	6000	96000	
		Бай	10	5000	50000	
		ШТМ	40	1540	61600	
		<b>Бүгд</b>				<b>357600</b>
<b>НИЙТ</b>					<b>1911100</b>	